

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/026-НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	12-14
4.1 Ерөнхий зүйл	12-13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14-15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төрийн албан хаагч
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ-ҮРЖЛИЙН ЦӨМ СҮРГИЙН
АЖ АХУЙ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2025.03.14 № СА-2025/026-НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөөгүй,
- Мал зүй бусаар хорогдсоноор бүртгээгдсэн боловч уг хорогдлыг малын эмчийн тогтоосон хорогдлын актаар баталгаажуулаагүй,
- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-т 2024 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь тайлант оны орлогыг **87,311.7** мянган төгрөгөөр, зардлыг **87,311.7** мянга төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр **78,822.1** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн, **80,703.5** мянган төгрөгийн зардал гаргаж, **1,881.4** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь тайлант онд 4 зорилт, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.5 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь *(Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл)* санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	654,465.20	13,979.20
1.1.2	Дансны авлага	7,100,000.00	7,880,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	-	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,660,000.00	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө /мал/	22,042,000.00	19,333,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	36,456,465.20	27,226,979.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,379,868.74	14,658,617.25
1.2.2	Биет бус хөрөнгө	36,780,000.00	36,780,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	55,159,868.74	51,438,617.25
1.3	Нийт хөрөнгийн дүн	91,616,333.94	78,665,596.45
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	450,000.00	450,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	7,432,997.00
2.1.1.3	Татварын өр	740,796.00	1,165,050.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	24,900.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	18,951,485.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	20,142,281.00	9,072,947.00
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	20,142,281.00	9,072,947.00
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	41,615,000.00	41,615,000.00
2.3.1	-төрийн	41,615,000.00	41,615,000.00
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,776,074.48	10,776,074.48
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,780,000.00	36,780,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(17,697,021.54)	(19,578,425.04)
2.3.11	Эздийн өмчийн дүн	71,474,052.94	69,592,649.44
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	91,616,333.94	78,665,596.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	24,439,450.00	52,452,615.00
2	Борлуулалтын өртөг	37,377,500.00	54,826,995.00
3	Нийт ашиг (алдагдал)	(12,938,050.00)	(2,373,380.00)
4	Түрээсийн орлого	950,000.00	1,573,000.00
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	27,126,500.00	24,795,500.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	23,720,846.75	22,484,508.50
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,161,000.00	3,343,500.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	48,515.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(9,743,396.75)	(1,881,403.50)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(9,743,396.75)	(1,881,403.50)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(9,743,396.75)	(1,881,403.50)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(9,743,396.75)	(1,881,403.50)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(14,825,768.04)	84,088,703.18
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(14,825,768.04)	84,088,703.18
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,871,253.50)	(2,871,253.50)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(17,697,021.54)	71,474,052.94
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,881,403.50)	(1,881,403.50)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	41,615,000.00	10,776,074.48	36,780,000.00	(19,578,425.04)	69,592,549.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	43,005,435.00	55,075,130.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	20,685,735.00	35,075,130.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	20,000,000.00	20,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,319,700.0	
1.2	Мөнгөн зарлагын дүн	52,775,125.00	55,715,616.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	33,272,014.00	33,329,103.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,265,080.00	8,900,400.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,085,500.00	6,674,895.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,042,102.00	657,307.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,968,205.00	3,290,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,793,494.00	2,293,461.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	348,730.00	570,450.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,769,690.00)	(640,486.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(9,769,690.00)	(640,486.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,424,155.20	654,465.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	654,465.20	13,979.2

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	төгрөг	87,311,700.0	78,822,115.0	(8,489,585.0)	90.3
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	28,330,000.0	54,826,995.0	26,496,995.0	93.5
3	Нийт зардал	төгрөг	87,311,700.0	80,703,518.5	6,608,181.5	92.4
	Үүнээс:	төгрөг	87,311,700.0	80,703,518.5	6,608,181.5	92.4
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	төгрөг	54,827,000.0	54,827,000.0	-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	төгрөг	32,484,700.0	25,876,518.5	6,608,181.5	79.7
4	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	-	(1,881,403.5)	(1,881,403.5)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Аймгийн аж ахуйн нэгж, иргэд байгууллагыг цэвэр үүлдрийн мал амьтдаар хангах,*
- *Цэвэр үүлдрийн мал амьтдын үр, үр хөврөл импортлох,*
- *Шилдэг малыг экспортлох,*
- *Цэвэр үүлдэр, түүний эрлийз малыг шилэн сонгох замаар шилдэг хээлтэгч, хээлтүүлэгч өсгөн бойжуулах,*
- *Аж ахуйн нэгж, иргэд байгууллагын малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж малын үүлдэрлэг байдал ашиг шимийг сайжруулах,*
- *Аж ахуйн нэгж, иргэд байгууллагыг холбогдох мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх,*
- *Шинэ техник технологи нэвтрүүлэх,*
- *Цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалан бататгах*

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2005 оны 6 дугаар 28-ны өдрийн 51 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл “*Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх*”, 19.1 дэх “*Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “*Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих*” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр*

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,950.8 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	654.5	14.0	(640.50)
Авлага	7,100.0	7,880.0	780.0
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	6,660.0	-	(6,660.0)
Бусад эргэлтийн хөрөнгө /мал/	22,042.0	19,333.0	(2,709.0)
Үндсэн хөрөнгө	18,379.9	14,658.6	(3,721.3)
Биет бус хөрөнгө	36,780.0	36,780.0	-
Нийт хөрөнгө	91,616.4	78,665.6	(12,950.8)
Өр төлбөр	20,142.3	9,072.9	(11,069.4)
Эздийн өмч	41,615.0	41,615.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	36,780.0	36,780.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,776.1	10,776.1	-
Хуримтлагдсан ашиг	(17,697.0)	(19,578.4)	(1,881.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	90,616.4	78,665.6	(12,950.8)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 14.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 640.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор,
- Авлагын дансны үлдэгдэл 7,880.0 мянган төгрөг болж, 780.0 мянган төгрөгөөр өссөн нь тооллогоор 26 мал дутаасныг малчнаас авах авлагаар бүртгэсэнээс,
- Урьдчилж гарсан зардал данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь тайлант хугацаанд 50 охин төлөг худалдан авснаас,
- Бусад эргэлтийн хөрөнгө 19,333.0 мянган төгрөг болж 3,721.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 8,660.0 мянган төгрөгийн мал худалдан авч, нас дэвшилтээр 6,703.5 мянган төгрөгийн малыг үнэ төлбөргүйгээр бүртгэн, 10,464.5 мянган төгрөгийг мал худалдан борлуулж, нас дэвшилтээр 1,908.0 мянган төгрөгийн мал зарлагадан, зүй бус хорогдлоор 3,343.5 мянган төгрөгийн мал хорогдсон зэрэг нийт 18,072.5 мянган төгрөгийн малыг зарлагадсанаас тус тус шалтгаалсан байна.

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулж, аймгийн ИТХ, Засаг даргаар батлуулаагүй бөгөөд тайлант оны орлогыг **87,311.7** мянган төгрөгөөр, зардлыг **87,311.7** мянга төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр **78,822.1** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн, **80,703.5** мянган төгрөгийн зардал гаргаж, **1,881.4** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 78,822.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 8,489.6 мянган төгрөг буюу 9.7 хувиар тасарсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт авлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн 46,950.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **469.5** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөж, баталсан төлөвлөгөөний хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 170 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, худалдан авах ажиллагаа нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 174 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах” тухай 2023 оны А/75 дугаар тушаалаар тус байгууллагыг түүвэрт хамруулан үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн бөгөөд ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **13,343.5** мянган төгрөгийн зөрчил илэрч, **3,343.5** мянган төгрөгийн 2 албан шаардлага, **10,000.0** мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Тус газрын 2024 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “**үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд **3,343.5** мянган төгрөгийн үнэ бүхий 78 толгой мал зүй бусаар хорогдсоноор бүртгэгдсэн боловч уг хорогдол нь малын эмчийн тогтоосон хорогдлын акт болон бусад баримтуудаар бүрэн нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “**Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно**”, 13.7 дахь “**Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэх, бүртгэл тайланд тусгахыг хориглоно**” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Малын тоо толгой, зарцуулалт, хорогдолд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн малын хорогдлыг хүлээн зөвшөөрч, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 2009 оноос хойш ашиглагдаагүй **10,000.0** мянган төгрөгийн хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмжийг акталж, устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.” 3.3 дахь “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийн акталж, устгах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

2.Хуримтлагдсан ашиг, алдагдал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр **1,881.4** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “**Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийх, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах зарчмыг хэрэгжүүлэх

Дээрх зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулаагүй	1	-			1							
Малын зүй бус хорогдлыг актаар баталгаажуулаагүй	1	3,343.5			1	3,343.5						
Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийн акталж, устгах	1	10,000.0					1	10,000.0				
Өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадаагүй алдагдалтай ажилласан	1						1					
Дүн	4	13,343.5			2	3,343.5	2	10,000.0				